



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНЫ СОНГОЛТ
ОНООС



Эрүүл хүнс - Таны сонголт



2019 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019



- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

АГУУЛГА

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

- Компанийн түүхэн товчоо
- Эрхэм зорилго, Үнэт зүйл
- Ажиллах хүчний нөөц

2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Зах зээлийн хувь хэмжээ
- Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний төрөл

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- Хураангуй тойм

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Хүний нөөцийн бодлого
- Нийгмийн хариуцлага

ОЛОЛТ АМЖИЛТ

2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

1

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

КОМПАНИЙН ТҮҮХЭН ТОВЧОО



БИДНИЙ ТҮҮХ

ҮЙЛДВЭРЛЭЖ БАЙГАА ТАЛХНЫ 50 ХУВИЙГ
ХӨХ ТАРИАНЫ ОЛОН ҮРТЭЙ ТАЛХ ЭЗЭЛДЭГ



1984 он “Талх чихрийн комбинат” нэртэйгээр ашиглалтанд орж талх 90 тонн, Чихэр 5000 тонн, Жигнэмэг, Өрмөнцөр, бялуу 6550 тонн, Жимсний чанамал 800 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэв.

1999 он “Талх чихэр” ХК болон хувьчлагдав.

2003 он БНСУ-ын Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх хөргүүртэй, хөргүүргүй тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, Тайвань улсын сахарын болон хатуу төрлийн жигнэмэгийн шугам ашиглалтанд оров

2004 он Микробиологи, Химийн лабораторид шинэчлэл хийж, дугуй талх үйлдвэрлэх компьютерын удирдлагатай иж бүрэн шугам ашиглалтанд оров.

2006 он Монгол улсдаа анх удаа зүссэн талхыг хэрэглэгчдэд хүргэв.

2008 он Герман, Украин улсуудад-Гурил шуудайгүйгээр тээвэрлэх тоног төхөөрөмжийг захиалгаар хийлгэв

2010 он БНЧУ, Голланд Нарийн боовны үйлдвэрлэлийн техник технологийг иж бүрэн шинэчилсэн

2010 он “ТаЧи”, “Органик” брэндийн нарийн боов худалдаанд гарав.

2012 он “Та Чи” 4 төрлийн баяжуулсан талхны урсгал шугам суурилуулав.

2013 он Талхны анхны бүрэн автомат савлагааны машин суурилуулав.

2013 он Дархан, Эрдэнэт хотуудад борлуулалтын баг томилон ажиллуулж анхны түгээлтээ хийв.

2014 он Монгол улсдаа анх удаа чаналгын бүтээгдэхүүний тос шүүгч бүрэн автомат урсгал шугамыг Итали улсын СЕРІ, CANOL, TECHNO-D, ЧЕХ улсын TOPOS фирмүүдэд захиалгаар үйлдвэрлүүлэв.

2014 он “Фрэнч баггет” брэндийг үйлдвэрлэж эхлэв.

2015 он Бородино, Сэндвич, Бургер талхыг үйлдвэрлэж эхлэв.

2016 он Талх, нарийн боовны үйлдвэрт тус бүр 30.000м³ бүрэн автомат агааржуулалтын системийг суурилуулав.

2017 он Азидаа анх удаа БНЧех улсын J4 компанийн хоёр давхар пийшинтэй талхны иж бүрдэл урсгал шугам ашиглалтанд оруулсан, Итали улсын СЕРІ компаниас 500тн гурил вакум орчинд хадгалах, дамжуулах зориулалт бүхий иж бүрэн системийг угсарч суурилуулав.

2018 он Талх 30 нэр төрөл, нарийн боов 35 нэр төрөл, бялуу болон бэйкери 60-н нэр төрөл, 10 гаруй нэр төрлийн жигнэмэг тус үйлдвэрлэж өдөр тутам Улаанбаатар хотын 3200 гаруй цэгт түгээлт хийж 500.000 өрхийг талх нарийн боовоор өдөр тутам хангаж байна.



- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

MISSION VISION VALUES



1

Эрхэм зорилго

Бид олон улсын чанарын стандартад нийцсэн дэвшилтэт технологиор бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, хэрэглэгч харилцагчдынхаа сэтгэл ханамжинд үнэлэгдсэн хүнсний салбарын загвар компани байна.

2

Алсын хараа

Хувьсан өөрчлөгдөх хэрэглээний соёлыг тодорхойлон, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байна

3

Үнэт зүйлс

Т - Тэргүүн технологи
А - Аюулгүй бүтээгдэхүүн
Ч - Чадварлаг ажилтан
И - Итгэлцэл, түншлэл






- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

КОМПАНИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НӨӨЦ

Нийт ажилтан

812


 **43,6%**
Male Users

 **56,4 %**
Female Users

Хөгжлийн
бэрхшээлтэй

 **32**

Нийт ажилтан насаар



Нийт ажилтан боловсрол



Дунд боловсролтой 6.9%

Бүрэн дунд боловсролтой
47.9%

Тусгай дунд боловсролтой
9.7%

Дээд боловсролтой 34.8%





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

2


2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ



Нийт **812** ажилтантайгаар **100 гаруй** нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, борлуулж **54,8** тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.


Ажилчид болон харилцагчид чиглэсэн нэгдсэн арга хэмжээг 2019 оны I-II улиралд хэрэгжүүлсэн. Үүнд 3000 харилцагчийг нэгтгэсэн, тэдгээрийн санал бодлыг сонссон арга хэмжээ, ажилчдын урам зориг, ажилдаа идэвх санаачилгатай байлгах зорилгыг өвөртөлсөн 2С нэгдсэн урлагийн наадам мөн ажилсан жилийн нэмэгдэл, байрны урьдчилгаа, гадаад болон дотоод аялал, сургалт семинар зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан.

АГУУЛГА


Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй. Нийт хувьцаа: 1,023,703ш

Зах зээлийн үнэлгээ: 14,352,316,060.00₮ 2018 онд нэгж хувьцааны ханш хамгийн өндөртөө 20,000₮ төгрөгт хүрч байсан.

Хаалтын ханш



Арилжигдсан ширхэг





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ



1

Ажилчдад чиглэсэн

Компанийн хэмжээнд нийт ажиллагсдын ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, мэргэжилтэн ажилтаны тогтвор суурьшилийг нэмэгдүүлэх

2

Үйлдвэрлэлт

Ургац, Unimax шугамын хүчин чадал ашиглалтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн тасралтгүй жигд ажиллагааг хангаж ажиллах

3

Чанар аюулгүй байдал

Лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах, чанар хяналтыг нэмэгдүүлж, ISO22000 стандартын дагуу чанар аюулгүй байдлыг хангах





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ /ГҮЙЦЭТГЭЛ/



1

Ажилчдад чиглэсэн

Компанийн хэмжээнд нийт ажиллагсдын ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, мэргэжилтэн ажилтаны тогтвор суурьшилийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Технологи болон Инженер техникийн ажилчдад ОХУ, Итали, ХБНГУ, БНХАУ-аас мэргэжилтэн ажилтан урьж сургалт семинарт хамруулсан

2


Үйлдвэрлэлт

Үйлдвэрийн явцад тулгарч буй саад бэрхшээлийг цаг тухай бүрт шийдэж байснаас гадна техникийн засвар үйлчилгээг хийж сул зогсолтыг бууруулснаар 8 тэрбум төгрөгний бүтээгдэхүүний борлуулалтыг зах зээлд нийлүүлж борлуулалтыг нэмэгдүүлсэн

3

Чанар аюулгүй байдал

Лабораторийн шинжилгээний тоног сорьц төхөөрөмжийн авах хурд хүчин чадлыг нэмэгдүүлж нарийвчлалыг сайжрууллаа.





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

3

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



**БИЗНЕС
ПРОЦЕССИЙН
БАРИМТЛАХ
СТРАТЕГИ**

**ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ГИНЖИН ХОЛБОО
УДИРДЛАГЫН
СТРАТЕГИ**

Үйл ажиллагааны гинжин хэлхээг оновчтой байдлаар ажлуулахын тулд бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэлт, борлуулалт, түгээлт болон харилцагч нарт хяналт тавих бодлого баримтлан ажиллах

**ХЭРЭГЛЭГЧ БА
МАРКЕТИНГИЙН
СТРАТЕГИ**

**ЗАХ ЗЭЭЛИЙГ
ӨРГӨЖҮҮЛЭХ,
БРЭНДИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ**

Зөвхөн бүтээгдэхүүн үйлдвэрлээд зарах бус, дата мэдээлэл, ажиглалт судалгаан дээр тулгуурлан хэрэглэгчдийн чиг хандлагад тулгуурлан сэтгэл ханамжийг тэргүүнд тавин ажиллах

Тайлант хугацаанд Зах зээлд гаргаж буй бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, мөн ISO 9001:2015, ISO 22000:2005, ISO/IEC17025:2007 стандартуудын шаардлагыг хангах зорилгоор үйлдвэрлэлийн талбайг өргөтгөх зайлшгүй хэрэгцээ бий болсон.

Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ, шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах ирээдүйн эрсдэл зэргийг тооцон үзэхэд хөрөнгө оруулалтыг компани дангаараа хийх нь үйлдвэрлэлийн жигд үйл ажиллагааг доголдуулах магадлалтай гэж үзэн сонирхогч хөрөнгө оруулагчидтай санал солилцож компанид хамгийн ашигтай байх хувилбараар хөрөнгө оруулалтыг татах ажлыг ТУЗ-тэй зөвшилцөн өгсөн чиглэлийн дагуу хийж гүйцэтгэлээ.


Сонгогдсон хөрөнгө оруулагчтай гэрээ хийсний үндсэн дээр түүхий эдийн агуулах, савлагааны цех, борлуулалтын ачилтын покс зэргийг өргөтгөлөө.

Ингэснээр ISO 9001:2015, ISO 22000:2005, ISO/IEC17025:2007 стандартуудын шаардлагыг хангасан төдийгүй нийслэл болон Хөдөө орон нутгийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг шинэлэг байдлаар нь хүргэхэд шаардлагатай хөргөлт, савлагаа, агуулах, хүргэлтийн цогц үйлчилгээг стандартын дагуу нэвтрүүлсэн.

Мөн байгууллагын хэмжээнд цаашид ашиглагдах боломжгүй техник, тоног төхөөрөмж, борлуулалтад ашиглагдаж байсан элэгдэж муудсан авто машин, хуучирсан ашиглах боломжгүй актлагдсан агуулах зэргийг зах зээлийн зохих үнэлгээг гарган ТУЗ-ийн зөвшөөрлийн дагуу худалдан борлууллаа.

Үүний зэрэгцээ зах зээлд өрсөлдөх чадвараа алдсан бялуу, нандин бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шинээр сэргээх зорилгоор холбогдох хөрөнгө оруулагчтай хамтран ажиллаж зах зээлд дахин нэвтрүүлэх ажлыг менежментийн гэрээний үндсэн дээр амжилттай зохион байгууллаа.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ ТҮҮНИЙ ТОО



Талх, талхан төрөл
Зах зээлийн **70%**
35 нэр төрөл



Нарийн боовны төрөл
Зах зээлийн 25%
36 нэр төрөл



Бэйкерийн бүтээгдэхүүн
Нэвтрэлтийн үе
100 гаруй нэр төрөл



- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -




ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮА ХҮИС 1984 ТАНЬ СОНГОЛТ
ОНООС

4

САНХҮҮГИЙН ТАЙЛАН






- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

2019 ОНЫ САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТОЙМ




Тус компани 2019 онд **54.855,8** сая төгрөгийн борлуулалт хийж, урьд оноос орлого **8.252,3** сая төгрөгөөр давуулж, зардлыг зохих түвшинд барьж ажилласнаар 2019.09.01-ний өдрөөс нийт ажилчдын цалинг 25%-иас 30%-иар нэмсэн.



НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
54.855.800.000



АЖИЛЧДЫН ЦАЛИНГИЙН ОРЛОГО
25-30% Нэмэгдсэн





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

5 ТОГТВОРТОЙ БАЙДАЛ





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО




Бид хурдацтай өөрчлөгдөн даяарчлагдаж буй энэхүү өрсөлдөөнт зах зээлд өндөр ур чадвартай баг хамт олныг бүрдүүлэх, салбартаа шинэ, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр анхдагч байхыг эрмэлзэж, байгууллагын соёл, хэрэглэгчийн сэтгэл ханамж, эргэх холбоогоор салбартаа тэргүүлэхийн зэрэгцээ, нийгмийн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулдаг нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч "Хүн төвтэй үйлдвэр" болох стратегийн чиглэлийг удирдлага болгон ажиллаж байна.



20 АЖИЛЧДЫН НЭГДСЭН УРЛАГ СПОРТЫН НААДАМ

Найрсаг хамт олны уур амьсгалыг бататгах, урлаг, спортын авьяасыг хөгжүүлэх үүднээс зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 800 гаруй ажилтантай 10 алба хэлтэс хамрагдсан том хэмжээний нэгдсэн арга хэмжээ болсон.





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО



Нийгмийн халамж


Ажилчдаа тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс

- Нийт ажилчдын 45 хувь нь ажилласан жилийн нэмэгдэлд хамрагддаг.
- Байгууллагын мөнгөн тусламж
- Сургалтын төлбөрийн тэтгэлэг
- Урлаг, спортын их наадам
- Бялдаржуулах танхимын байнгын үйл ажиллагаа
- Байрны урьдчилгааны хүүгүй зээл гэх зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн.

Сургалт, хөгжүүлэлт

Нийт 1800 хүн дотоод сургалтын /давхардсан тоогоор/ 41 чиглэлийн сургалтанд хамрагдсан Гадаад улсад: БНХАУ, Өвөр Монгол Хятад Монголын хамтарсан үзэсгэлэн худалдаа болон Европын холбооны улсуудын харилцагч байгууллагад туршлага судлах зэргээр Европын холбооны улсуудад шилдэг тэргүүний албан тушаалтан томилогдон явсан.

Мөн БНХАУ болон ХБНГУ, ОХУ болон Итали улсуудаас 7 удаагийн мэргэжилтэн авчран сургалт семинар явуулсан байна.






- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



2019 онд нийгмийн хариуцлагын хүрээнд “Талх Чихэр” ХК шат дараатайгаар дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна.

- Цагдаагийн ерөнхий газрын Хэрэг бүртгэх албатай хамтран “Хүүхдэд тусалъя” сайн үйлсийн аян
- “Зулзага инээмсэглэл” ТББ хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн шинэ жилийн баяр
- Онцгой харилцагчдын баяр
- Онцгой хүүхдүүд хүүхдийн баярын арга хэмжээ
- Улаанбаатар марафон дэмжигч байгууллага
- 4 удаагийн хандивын аян
- Пластик уутны хэрэглээг багасгах зорилгоор “Ухаалаг хэрэглэгч” урамшуулалт аян
- Ажилчдийн дэмжлэг санаачилгатайгаар зорилтот бүлгийн иргэдэд хүнсний бүтээгдэхүүн гэсэн ажлуудыг хийсэн байна.





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



ҮЛГЭР ЖИШЭЭГ УРИАЛАХ

Компанийн өөрийн эзэмшлийн талбай дээр шинэ жилийн баярыг тохиолдуулан өвлийн өвгөн, сүлд мод, болон баригдаж буй барилгын гадна чимэглэл бүтээсэн бол сар шинийн баярыг тохиолдуулан таван хошуу мал, малчин өрхийг илтгэх жижиг байгууламжаар болон барилгын гадна гэрэлт чимэглэлээр харилцагч, хэрэглэгчдэдээ хүндэтгэл үзүүлсэн.

Тус ажлыг хэрэгжүүлснээр нийслэлийн болон Сонгино хайрхан дүүргийн хорооны хүүхдүүдийг гадаа талбайд тоглох, өв соёлоо таниулан сурталчилах арга хэмжээ болж өгдөг.



“Сайн байцгаана уу? Хөдөлмөрийн баатруудаа” арга хэмжээг 7 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж нийтдээ 120 баатруудыг хүлээн авч сар шинийн тавгийн идээгээр бэлэг барьсан.

Мөн уламжлал ёсоор “Талх чихэр”ХК-ийн 200 гаруй ахмадуудаа хүлээн авч сар шинийн тавгийн идээний хэвийн боов болон бусад гарын бэлгийг өгч ахмад буурлуудаа баярлуулж үнэт сургаалийн сонссоор ирсэн.



- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

ОЛОЛТ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Зах зээлд өрсөлдөх чадвараа алдсан бялуу, нандин бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шинээр сэргээх зорилгоор холбогдох хөрөнгө оруулагчтай хамтран ажиллаж зах зээлд дахин нэвтрүүлэх ажлыг менежментийн гэрээний үндсэн дээр амжилттай зохион байгуулан ажиллаж байна.





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

ОЛОЛТ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



“Талх чихэр” ХК-нийг анх үүсгэн байгуулагдсан цагаас хойш ажилласан ахмад туршлагатай ажилчдын “Хөдөлмөр” алдар тэмдэглэх арга хэмжээг зохион байгуулав






- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

ОЛОЛТ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ОНЦГОЙ ХАРИЛЦАГЧДЫН БАЯР

3000 харилцагчдыг нэгтгэсэн томоохон арга хэмжээг UB паласын концертын их танхимд явуулсан. Тус арга хэмжээ нь харилцагчдын үйл ажиллагааны онцлогт тулгуурласан бодит ажлыг хэрэгжүүлэхийг амласан, харилцагчид бодит урамшууллыг бий болгосон нэгдсэн том арга хэмжээ болж өндөрлөсөн.





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

ОЛОЛТ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



УХААЛАГ ХЭРЭГЛЭГЧ ХӨТӨЛБӨР


Зорилт

Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэглэгчдийг нийлэг гялгар уутнаас татгалзаж, даавуун торыг хэрэглэхийг уриалсан

Зорилго

20 бүтээгдэхүүний уут 1 даавуун тор уриатай арга хэмжээг зохион байгуулснаар байгаль орчинд хортой гялгар уутыг багасгаж хэтийн зорилго бүхий 2025 онд хотын өнцөг булан бүрт хягдал гялгар уут ангилан хаях хогийн сав байрлуулах төлөвлөгөөг нийтээрээ биелүүлэхийг уриалсан анхдагч ажил болж өгсөн.

Мөн “Талх чихэр” ХК-иас худалдан авсан бүтээгдэхүүн бүрийн уутыг авч дахин боловсруулах үйлдвэрт өгч траншейны таг, хогийн сав, автобусны буудлын сандал зэргийг хороондоо хандивласан.





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -


ОЛОЛТ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



“Талх Чихэр” компани ISO 9001:2015 шинэчлэгдсэн хувилбарын дагуу батламжаа нэг сард гардан авсан. Манай компани нь 2015 онд ISO9001:2008 стандартын хувилбарыг үйлдвэртээ нэвтрүүлсэн бөгөөд 2018 оны 12 сарын 28 ны өдөр баталгаажуулалтын хуралд орсноор ISO9001:2015 чанарын удирдлагын тогтолцооны шинэчилсэн хувилбарыг гурван жилээр сунгах эрхээ ийнхүү авч чадсан юм. Мөн 2019 онд ISO9001:2015 стандартын дахин баталгаажуулалтыг хийлээ.



Олон улсын хүнсний аюулгүй байдлын стандарт ISO 22000:2005 нэвтрүүлснээр хэрэглэгчид чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан, бүтээгдэхүүн хэрэглэж, сэтгэл хангалуун үйлчлүүлэх боломжийг олгож байдаг. 2019 онд стандартын гэрчилгээг баталгаажуулах шалгалтанд орж олон улсын стандартыг хэрэгжүүлэх эрхээ дахин авч чадсан.





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

ОЛОЛТ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



“Намрын ногоон өдрүүд-2019” үзэсгэлэн худалдаанд 14 дэхь жилдээ амжилттай оролцсон. Тус үзэсгэлэнд Түмэн насан брэндийн өнгө төрх бүхий тохижилт өв уламжлал сурталчилан оролцож “Талх Чихэр” ХК-ийн үйлдвэрлэдэг жигнэмэгэн бүтээгдэхүүн “Хүнсний экспортын шилдэг” өргөмжлөл цомыг гардаж авсан






- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -

2020 ОНЫ ЗОРИЛТ



- 1. Компаний хэмжээнд нийт ажилчдаа мэргэшүүлэх, гадаад болон дотоодын тэмцээн уралдаанд оролцох, ур чадвараа нэмэгдүүлэх сургалт семинарт хамруулах. Ингэснээр мэргэжлийн ажилтны тогтвор суурьшилийг нэмэгдүүлэх**
- 2. Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн шинэ бодлого баримталж дэлхийн стандартад нийцсэн олон улсын зах зээл дээр худалдаалагдаж байгаа бүтээгдэхүүнийг эх орондоо нутагшуулах, шинэ хэрэглээний соёл бий болгох**
- 3. Харилцагч, хэрэглэгчидтэй харилцах бодлогод сайжруулалт хийх, цахим худалдааны үйлчилгээг нэвтрүүлэх**





- 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН -



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮА ХҮИС 1984 ТАНЬ СОНГОЛТ
ОНООС

АНХААРАЛ ТАВЬСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА

